


ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН  
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
Д.ГАНЦЭЦЭГ



## ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2018 оны 12 сарын 20-ны өдөр

№

Улаанбаатар хот

**2018.12.21.272**  
**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү Худалдах, худалдан авах (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв (цаашид “Худалдан авагч” гэх), түүнийг төлөөлж Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Аж ахуйн менежер Ч.Тунгалаг, нөгөө талаас “Би Жи Эм Интернэйшнл” ХХК, (цаашид “Худалдагч” гэх), /регистрийн дугаар 6181368/ түүнийг төлөөлж менежер Т.Алтангэрэл нар (цаашид хамтад “Талууд”, тус тусад нь “Тал” гэх) Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлийг үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцон байгуулав.
- 1.2. Энэхүү гэрээний дагуу Худалдагч нь ЭМХТөвийн төв байрны 1-3 давхрын шат, корридорын 70м2 дрозжыг нэг бүрийн үнэ 71,000 төгрөгөөр мөн 202 тоот өрөө, хурлын заал, корридор шатанд дрозж суурилуулах, цавууны үнэ болон ажлын хөлс багтсан болно. Гэрээнд заасан хугацаанд сонгосон өрөө тасалгааны шаланд битүү дүүргэлттэйгээр, стандартын дагуу суурилуулах ажлыг гүйцэтгэх Худалдан авагчид хүлээлгэн өгөх, тайлагнах, нөгөө талаас Худалдан авагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага болон тэдгээртэй холбогдсон бусад харилцааг тодорхойлох, зохицуулахад оршино.

## ХОЁР.ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Гэрээний үйлчлэх хугацаа: 2018.12.20-2018.12.28
- 2.2. Хугацааг тоолохдоо гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хуанлийн тооллыг удирдлага болгоно.

## ГУРАВ.ГЭРЭЭНИЙ ҮНЭ, АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР

- 3.1. Гэрээний нийт үнийн дүн нь 7.826.200 (Долоон сая найман зуун хорин зургаан мянга хоёр зуу) төгрөг байна. Үүнд барааны хүргэлт, суурилуулалт, НӨАТ болон бусад бүх төлбөр, зардлыг оруулсан болно.
- 3.2. Талууд гэрээ байгуулж, Худалдан авагч нь Худалдагчийн нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор гэрээний төлбөрийг Голомт банкны 1415112953 тоот дансанд шилжүүлнэ.



3.3. Гүйцэтгэгч нь гэрээ байгуулсны дараа гэрээний үнийг нэмэгдүүлэх эрхгүй.

### **ДӨРӨВ. АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ**

4.1. Худалдан авагч нь гэрээний зүйлийг шалган актаар баталгаажуулан хүлээн авна. Уг акт нь гэрээний салшгүй хэсэг болно.

### **ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

5.1. Худалдан авагчийн эрх, үүрэг:

- 5.1.1. Худалдагч нь гэрээнд заасан тоо хэмжээнээс дутуу, биет байдлын доголдолтой, чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн нийлүүлвэл хүлээн авахаас татгалзах эрхтэй.
- 5.1.2. Гэрээнд зааснаас зөрүүтэй болон стандартын шаардлага хангаагүй тохиолдолд хүлээн авахаас татгалзах, дахин нийлүүлэхийг шаардах, шаардлагыг хүлээн аваагүй тохиолдолд 3 дагч этгээдээр нийлүүлэх, үүнтэй холбогдон гарсан зардлыг Худалдагч талаар нөхөн төлүүлэх (төлөх ёстой төлбөрөөс суутган авах) эрхтэй.
- 5.1.3. Худалдан авагч нь гэрээнд заасан үнийг төлөх үүрэгтэй.
- 5.1.4. Худалдагч нь шаардлага хангаагүй гэрээний зүйлийг үнэ төлбөргүй буюу өөрийн зардлаар дахин/нөхөж нийлүүлэх боломжгүй буюу гэрээнд заасан хугацаанд амжихгүйгээр хугацаа алдсан тохиолдолд Худалдан авагч төлбөрийг буцаан нэхэмжлэх эрхтэй.
- 5.1.5. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэгтэй.

5.2. Худалдагчийн эрх, үүрэг:

- 5.2.1. Худалдагч нь худалдан авагчийн өмчлөлд гэрээнд заасан хугацаанд биет байдлын доголдолгүй, заасан тоо ширхэг, чанар, үзүүлэлт бүхий бүтээгдэхүүнийг нийлүүлнэ.
- 5.2.2. Худалдсан бүтээгдэхүүн нь доголдолтой бол худалдагч нь доголдлыг арилгах, гэрээнд зааснаас зөрсөн, өөрчлөгдсөн, чанарын шаардлага хангаагүй тохиолдолд тухайн шаардлага хангаагүй гэрээний зүйлсийг дахин үнэ төлбөргүй нийлүүлэх үүрэгтэй.
- 5.2.3. Худалдагч нь энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс худалдан авагч болон гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг дангаар хариуцан арилгах үүрэгтэй.
- 5.2.4. Худалдан авагчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
- 5.2.5. Худалдагч нь гэрээний төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөхийг шаардах эрхтэй.
- 5.2.6. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэгтэй.

### **ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА**

6.1. Худалдагч тал барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөөгүй буюу чанарын доголдлыг тогтоосон хугацаанд арилгаагүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гэрээний үнийн дүнгийн 0,1 хувиар алданги тооцно.



- 6.2 Алданги төлсөн нь талуудыг гэрээнд заасан үүргээ биелүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.

### **ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**


- 7.1. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал, зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх аргаар эвийн журмаар шийдвэрлэнэ.
- 7.2. Хэрэв маргаанаа зөвшилцөх аргаар шийдвэрлэж чадахгүйд хүрвэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

### **НАЙМ. БУСАД ЗҮЙЛ**

- 8.1. Гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, гэрээг цуцалснаар буюу гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно.
- 8.2. Гэрээ нь талуудын эрх ашиг, сонирхлын төлөө байгуулагдсан бөгөөд талуудын хувьд зайлшгүй дагаж мөрдөх баримт бичиг мөн.
- 8.3. Аль нэг талын хүсэлтээр гэрээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож, зөвшилцсөний үндсэн дээр гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 8.4. Гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 8.5. Гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

  
Эрүүл мэндийн хөгжлийн төвийн  
Аж ахуйн менежер.  
Ч.Тунгалаг  
Утас 99062485

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

  
“Би Жи Эм Интернэйшнл” ХХК-ны  
менежер. Т.Алтангэрэл  
Утас 89118009

